



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 11 өдөр

Дугаар A/100

Мөрөн сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлagnaх журам”-ын 4.3, 4.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд хийгдэж байгаа дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг газар дээр нь хянаж, жил бүр дүгнэж биелэлтийг хангулж ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

П.Мөнхжаргал - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Ё.Батсайхан - аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн бодлого үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн

Б.Даваасүрэн- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Улсын ахлах байцаагч,

Ц.Лхачинбат- Дэлгэрмөрөн сум дундын ойн ангийн дарга

Б.Золжавхлан –Хөвсгөл нуур эгийн голын сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн

Ч.Батбаяр –Хатгал тосгоны байгаль орчны хяналтын улсын байцаагч

Д.Галбаяр- Хатгал тосгоны байгаль хамгаалагч

М.Батчимэг-Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн

Хөвсгөл аймаг дахь ажилтан

Орон нутгийн иргэний төлөөлөл-1

Нарийн бичгийн дарга:

А.Цогзолсүрэн-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хяналт үнэлгээ, уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллагын тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг газар дээр нь шалгаж, үнэн зөв дүгнэж, биелэлтийг ханган ажиллахыг ажлын хэсэг (П.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.



ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6710010312